



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Эрүүгийн хэрэг)¹

ХОРИХ АНГИЙН АХЛАХ ТӨЛӨӨЛӨГЧ НЬ НИЙТИЙН АЛБАН ТУШААЛТАНД ХАМААРНА

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2024/ХШТ/86

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгосон.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Хорих ангийн ахлах төлөөлөгч **А** нь тус хорих ангийн “Арга зүйн зөвлөл”-ийн хуралдаанд санал өгөх эрхтэй гишүүний бөгөөд шүүгдэгч **Б**-г хугацааны өмнө тэнсэн суллахыг дэмжсэн санал өгнө гэж түүнээс 3,000,000 төгрөгийг хахуульд авч, улмаар “Арга зүйн зөвлөл”-ийн хуралд **Б**-ыг хугацаанаас өмнө суллахыг дэмжсэн санал өгсөн гэмт хэрэгт, харин **Б** нь хугацааны өмнө суллагдахаар Арга зүйн зөвлөлд санал өгөх эрхтэй **А**-д хахууль өгсөн гэх гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Анхан шатны шүүхээс:** Шүүгдэгч **А**-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт² заасан “Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд хахууль авах” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 1 жилийн хугацаагаар хорих ялаар, шүүгдэгч **Б**-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт³ заасан “Өөртөө давуу байдал бий болгох зорилгоор бусдад албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын

¹Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3607?daterange=2024/01/01%20-%202024/06/29%20&id=3&court_cat=2&bb=1

² Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйл. Нийтийн албан тушаалтан хахууль авах. “1. Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.

³ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.5 дугаар зүйл. Хахууль өгөх. “1. Өөртөө, эсхүл бусдад давуу байдал бий болгох зорилгоор бусдад албаны чиг үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан мөнгө, эд зүйл өгсөн, эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрхийг шилжүүлсэн, төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн, эсхүл эдгээрийг амласан, санал болгосон бол нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.



байдалтай нь холбогдуулан хахууль өгөх” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, нийтийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 1 жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэжээ.

2. **Давж заалдах шатны шүүхээс:** “...Хахууль авах гэмт хэргийн шинж нь “Нийтийн албан тушаалтан хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлсний хариуд, эсхүл хэрэгжүүлэхийн тулд, эсхүл хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд, эсхүл бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан” үйлдэл байдаг. Гэтэл шүүгдэгч А нь хоригдол Б өөрийн эрх мэдлийн хүрээнд Арга зүйн зөвлөлийн хуралд дэмжих санал өгөх талаар харилцан тохиролцоогүй, хоригдлыг хугацаанаас нь өмнө тэнсэн суллах эрх мэдэл бүхий албан тушаалтан биш, харин “албан тушаалын байдал” буюу албаны эрх нөлөөгөө ашиглан хоригдлын амьдрах бүсэд нэвтрэн прокурорын нэрийг барьж “нэг айлын хүргэн, баз, хувийн харилцаатай” мэтээр хуурч, 3,000,000 төгрөгийг авч, хувийн хэрэгцээнд зарцуулсан үйл баримт тогтоогдож байна” хэмээн үзэж Прокуророос А-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг *Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д зааснаар зүйлчилж, түүнийг албан тушаалын байдлаа ашиглан залилах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, шүүгдэгч Б-д холбогдох хэргийг гэмт хэргийн шинжгүй хэмээн хэрэгсэхгүй болгож түүнийг цагаатгаж шийдвэрлэжээ.*
3. Хяналтын шатны шүүхэд прокурор “... Хээл хахууль авах гэмт хэрэг нь хахууль авагч тал нь өөртөө ашиг олох, нөгөө тал нь ажил хэргээ бүтээх гэсэн авах, өгөх хоёр талын сонирхлын үүднээс асуудлыг шийдвэрлүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас нийгмийн шударга ёсыг зөрчсөн байдаг. А-ын үйлдлийг залилан гэж үзвэл хэн нэгэн этгээд энэ гэмт хэргийн улмаас хохирсон хохирогч байх ёстой, гэтэл дээрх хэрэгт хохирогчоор тогтоогдсон этгээд байхгүй бөгөөд шүүгдэгч Б нь нэг ч гэсэн хоног хугацааны өмнө хорих байгууллагаас суллагдахаар буюу өөртөө давуу байдал бий болгох зорилгоор А-д хахууль өгсөн гэмт хэргийг үйлдсэн ба шүүгдэгч А-ын хоригдогч Б-ээс 3,000,000 төгрөг авсан үйлдэл нь залилах гэмт хэргийн шинжгүй юм” гэсэн эсэргүүцлийг гаргажээ.
4. **Хяналтын шатны шүүхээс:** “...Давж заалдах шатны шүүх хэргийн үйл баримтын дүгнэлтэд ноцтойгоор нөлөөлж болохуйц гэрч нарын мэдүүлэг, бусад нотлох баримтыг бүрэн бодитойгоор харьцуулан үзэлгүй орхигдуулсан, *шүүгдэгч нарын үйлдэлд үндэслэл бүхий эрх зүйн дүгнэлт хийж чадаагүйн улмаас зөвхөн хэргийн төгсгөл, үр дагаварт тулгуурласан байдлаар үйл баримтыг буруу тогтоож, “албан тушаалын байдал” буюу албаны эрх нөлөөгөө ашиглан хоригдлын амьдрах бүсэд нэвтрэн прокурорын нэрийг барьж “нэг айлын хүргэн, баз, хувийн харилцаатай” мэтээр хуурч, 3,000,000 төгрөгийг авч, хувийн хэрэгцээнд зарцуулсан гэж дүгнэн шүүгдэгч А-д холбогдох хэргийг залилах гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн гэж зүйлчлэлийг өөрчилж, Б-д холбогдох хэргийг гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгасан нь үндэслэлгүй болжээ.* (39)⁴
5. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 17 дугаар бүлэгт заасан залилах гэмт хэрэг нь гэмт этгээд өөрийн үйлдлийг хууль ёсны гэсэн хуурамч сэтгэгдлийг өмчлөгчид төрүүлж, эд хөрөнгийг нь сайн дурын үндсэн дээр өөртөө шилжүүлэн авдаг бөгөөд ингэхдээ гэмт үйлдлээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө тухайн эд хөрөнгө, түүнийг эзэмших, өмчлөх эрхийг буцааж өгөхгүй байх, хариу төлбөрийг хийхгүй гэсэн санаа зорилгыг агуулдгаараа бусад гэмт хэргүүдээс ялгагдана. Шүүгдэгч А-ыг албан тушаалын байдлаа ашиглан

⁴ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



залилах гэмт хэрэг үйлдсэн гэж дүгнэх хууль зүйн үндэслэл, үйл баримт, хэрэгт авагдсан нотлох баримтаар тогтоогдохгүй байна.(40)

6. Монгол Улсын нэгдэн орсон Авлигын эсрэг НҮБ-ын конвенц болон Эрүүгийн хуулийн 22.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан **хахууль авах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив шинжийг судлан үзвэл тусгай субъект буюу нийтийн албан тушаалтан гэм буруугийн зөвхөн шууд “санаатай” хэлбэрээр хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албаны чиг үүргээ хэрэгжүүлээгүйн хариуд, эсхүл хэрэгжүүлэхгүй байхын тулд, эсвэл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн, эсхүл хийхийн тулд шууд болон бусдаар дамжуулан хахууль өгөхийг шаардсан, авсан байх шинжийн нэгдлийг гэмт хэрэгт тооцохоор зохицуулжээ. (43)**
7. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 10 дугаар зүйлийн 10.1.3-т төрийн албан тушаалын ангилал, төрлийг тус тус тодорхойлсон бол мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6-д зааснаар **шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын офицер, ахлагч, ажилтан төрийн тусгай албан тушаалтанд хамаарахаар хуульчилсан байна. Шүүгдэгч А гэмт хэрэг үйлдэх үедээ ... аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дугаар нээлттэй хорих ангийн ахлах төлөөлөгчөөр ажиллаж байсан нь Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар нийтийн албан тушаалтан гэж үзнэ. (44), (45).**
8. Шүүгдэгч А нь нийтийн албан тушаалтан буюу хорин ангийн ахлах төлөөлөгчөөр ажиллаж байхдаа хоригдол Б-ын ашиг сонирхлын үүднээс түүнтэй хувийн харилцаа тогтоож, хахууль авсан, шүүгдэгч Б нь хугацааны өмнө суллагдахаар буюу өөртөө давуу байдал бий болгох зорилгоор тус ангийн ахлах төлөөлөгчөөр ажиллаж байсан А-д хахууль өгсөн үйл баримт тогтоогдсон байна хэмээн үзэж Говьсүмбэр аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээн шийдвэрлэжээ.